



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Улаангомьын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: УВА-2024/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2024 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: Т.Намжил
Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
3.5.1 Төсвийн төлөвлөлт
3.5.2 Төсвийн гүйцэтгэл
3.5.3 Нэмэлт төсөв
4. АУДИТЫН ТАЙЛАН
4.1 Ерөнхий зүйл
4.2 Материаллаг байдал
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
4.5.1 Завсрын аудитын талаар
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

“УЛААНГОМЫН ДУЛААНЫ
ХОЁРДУГААР СТАНЦ” ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Э.БААТАРСАН ТАНАА

2024.03.15 № УМА-2024/01/НА-СТА-ТӨА
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 152/ШШ2022/00101 дугаар болон 152/ШШ2022/00238 дугаар захирамжаар өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг буруу тооцож олгосонтой холбоотой 2 ажилтны нэхэмжлэлийн дагуу нийт 16,018.0 мянган төгрөгийг тухайн ажилтануудад нөхөн олгосон байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас

0200200808

аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	110,021,021.41	104,171,442.58
1.1.2	Дансны авлага	267,057,651.50	683,897,793.11
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага	26,147,406.42	3,327,528.72
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	140,815,138.41	443,257,535.37
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,157,920.00	69,689,120.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	3,200,000.00	
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	553,399,137.74	1,304,343,419.78
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	11,305,237,363.10	15,943,106,793.94
1.2.2	Биет бус хөрөнгө	502,490,000.08	497,740,000.08
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,807,727,363.18	16,440,846,794.02
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,361,126,500.92	17,745,190,213.80
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	819,739,477.45	1,543,555,228.62
2.1.1.2	Цалингийн өглөг	2,387,994.57	
2.1.1.3	Татварын өр	20,310,569.21	194,958,327.73
2.1.1.4	НДШ – ийн өглөг	30,858,271.96	1,780,799.99
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	9,756,247.04	9,901,922.78
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	70,047,656.78	9,820,599.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) -д хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	953,100,217.02	1,760,016,878.13
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		

2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	953,100,217.02	1,760,016,878.13
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	13,141,086,944.47	13,175,741,444.47
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	161,243,643.48	161,243,643.48
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	527,104,293.06	6,266,488,243.06
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,421,408,597.11)	(3,618,299,995.34)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	11,408,026,283.90	15,985,173,335.67
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,361,126,500.92	17,745,190,213.80

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,609,822,409.20	4,311,375,402.73
2	Борлуулалтын өртөг	4,063,676,100.26	5,443,577,234.44
3	Нийт ашиг(алдагдал)	(453,853,691.06)	(1,132,201,831.71)
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		1,452,047.15
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал	106,791,547.12	128,513,994.24
10	Ерөнхий ба удирдлагын зардал	721,537,233.49	679,604,754.85
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	1,056.65	1,811.40
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	356,025,579.93	1,304,387,554.55
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(926,157,948.40)	(634,482,790.50)
19	Орлогын татварын зардал		145,204.72
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(926,157,948.40)	(634,627,995.22)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(926,157,948.40)	(634,627,995.22)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		

	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(926,127,948.40)	(634,627,995.22)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	12,324,965,430.47	161,243,643.48	1,310,608,117.26	(1,495,250,648.71)	12,301,566,542.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(926,157,948.40)	(926,157,948.40)
Өмчид гарсан өөрчлөлт	816,121,514.00		(783,503,824.20)		32,617,689.80
Зарласан ногдол ашиг					
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	13,141,086,944.47	161,243,643.48	527,104,293.06	(2,421,408,597.11)	11,408,026,283.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(562,263,403.01)	(562,263,403.01)
Залруулсан үлдэгдэл	13,141,086,944.47	161,243,643.48	527,104,293.06	(2,983,672,000.12)	10,845,762,880.89
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(634,627,995.22)	(634,627,995.22)
Өмчид гарсан өөрчлөлт	34,654,500.00		5,739,383,950		5,774,038,450.00
Зарласан ногдол ашиг					
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	13,175,741,444.47	161,243,643.48	6,266,488,243.06	(3,618,299,995.34)	15,985,173,335.67

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,442,934,172.95	5,717,392,030.36

	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,999,959,265.18	4,265,576,609.44
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	382,100,000.00	1,300,000,000.00
	Бусад мөнгөн орлого	60,874,907.77	151,815,420.92
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,304,192,534.12	5,384,504,412.19
	Ажиллагчдад төлсөн	1,097,088,088.00	1,623,955,364.79
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	315,745,268.35	506,139,771.39
	Бараа материал худалдан авахад төлсөн	943,539,535.72	882,118,959.00
	Ашиглалтын зардалд төлсөн	707,700,909.72	772,684,384.09
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	510,552,608.96	918,867,162.00
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	295,916,938.07	472,975,024.70
	Даатгалын төлбөрт төлсөн	540,352.00	472,387.00
	Бусад мөнгөн зарлага	433,108,833.30	207,291,359.22
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	138,741,638.83	332,887,618.17
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүгийн орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	61,868,545.46	338,737,197.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	57,823,545.46	338,737,197.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	4,045,000.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(61,868,545.46)	(338,737,197.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		

3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	76,873,093.37	(5,849,578.83)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,147,928.04	110,021,021.41
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	110,021,021.41	104,171,442.58

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны мөн үе	2023 он 4-р улирал		Өөрчлөлт (+өсөлт,-бууралт)	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	өнгөрсөн оны мөн үеэс	төлөвлөгөөнөөс
1	Үйлдвэрлэсэн дулаан	мян.Гкал	69.2	73.0	72.6	3.4	(0.4)
2	Шугамын алдагдал /биетээр/	мян.Гкал	5.00	5.00	5.00	-	-
	Шугамын алдагдал /хувиар/	хувь	3.40	3.65	3.65	-	-
3	Борлуулсан дулаан	мян.Гкал	65.8	69.4	69.0	3.4	(0.4)
4	Нийт орлого :	мян.төг	3,965,848.0	5,421,690.1	5,617,201.3	1,651,353.3	195,511.2
	Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны орлого	мян.төг	3,609,822.4	4,412,600.0	4,311,375.4	701,553.0	(101,224.6)
	Санхүүжилт /Улсын төсвийн татаас/	мян.төг	181,818.1	909,090.1	1,181,818.2	1,000,000.1	272,728.1
	Санхүүжилт /Улаангом сумаас зуны ХХУ/	мян.төг	100,000.0	100,000.0	109,090.9	9,090.9	9,090.9
	Үйл ажиллаганаы бус орлого	мян.төг	74,207.5		14,916.8	(59,290.7)	14,916.8
5	Нийт зардал	мян.төг	4,892,005.9	6,203,504.6	6,251,829.3	1,359,823.4	48,324.7
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал	мян.төг	4,892,005.9	6,203,504.6	6,251,829.3	1,359,823.4	48,324.7
	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	-			-	-
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	мян.төг	783,402.0	783,402.0	1,054,361.1	270,959.1	270,959.1
6	Нийт ашиг алдагдал	мян.төг	(926,157.9)	(781,814.5)	(634,628.0)	291,529.9	147,186.5
7	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	төг	1.36	1.41	1.45	0.09	0.04
8	Нийт авлага :	мян.төг	293,205.5	194,438.7	687,225.3	394,019.8	492,786.6
9	Нийт өглөг :	мян.төг	953,100.0	121,152.2	1,760,016.8	806,916.8	1,638,864.6
	Үүнээс: Урт хугацаат өр төлбөр	мян.төг	-	-	-	-	-
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	953,100.0	582,719.0	1,760,016.8	806,916.8	1,177,297.8

10	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	мян.төг	362,300.0	534,188.0	491,151.9	128,851.9	(43,036.1)
11	Ажиллагсадын тоо	тоо	93.0	93.0	92.0	(1.0)	(1.0)
12	Нийт цалингийн сан	мян.төг	1,247,652.5	1,884,907.7	1,848,178.1	600,525.6	(36,729.6)

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 181,348.2 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 171,048.2 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 10,300.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

1. “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК нь тайлант онд шинээр нэмэгдсэн 11 нэр төрлийн 419,884.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нэмэгдсэн өртөгийн албан татвар хассан дүнгээр буюу 381,712.7 мянган төгрөгөөр бүртгэлд тусгаж үндсэн хөрөнгийн үлдэгдлийг 38,171.3 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, НББОУС 16 үндсэн хөрөнгө стандартын өртөгийн бүрэлдэхүүн хэсгүүдэд “Худалдан авсан үнэ, гаалийн татвар, буцаан олгоогүй худалдааны татварын дүн”, “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.4-д үндсэн хөрөнгийн бүртгэл, 4.4.1-ийн 5-д Үндсэн хөрөнгийн үнэлгээ, 5.А-д Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн үеийн хөрөнгийн үнэлгээ хэсэгт “Үндсэн хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан хөрөнгүүдийг өртгөөр нь буюу анхны өртөг /түүхэн/-өөр үнэлж бүртгэлд тусгана”, “Худалдан авах замаар олж бэлтгэсэн хөрөнгийн анхны өртөгт дараах зүйлс багтана. Үүнд: Худалдан авсан үнэ, гаалийн татвар, нэмэгдсэн өртөгийн албан татвар” гэсэн заалт болон толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

2. “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК нь өр төлбөр дансны үлдэгдэлийг Нэмэгдсэн өртөгийн албан татварын 132,876.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 дахь заалтад “Бүх өр төлбөр” гэсэн заалт болон толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

3.1 Зөвлөмж

Илрүүлэлт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Автомашин сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм”-ын 5.5 дахь хэсэгт “Автомашин үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний доод хязгаар”, 5.5-ын тайлбар хэсэгт “Автомашин үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний нөөцийн доод хязгаарын нормыг тухайн эд ангийг үйлдвэрлэсэн үйлдвэрлэгчийн тогтоосон эдэлгээний нөөцийг үндэс болгон аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө тогтоож мөрдөнө”, “Тухайн эд ангид тогтоосон эдэлгээний нөөц тодорхой бус үед хүснэгт 5.5-д заасан эдэлгээний нөөцийг баримжаа болгон аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө тогтоож мөрдөж болно” гэж заасан байхад үндсэн агрегат, зангилаануудын эд ангийн доод хязгаарын нормыг тооцохгүйгээр 10,300.0 мянган төгрөгөөр Шланз машины 420 маркийн моторыг худалдан авсан байна.

Өгсөн зөвлөмж:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Автомашин сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм”-ыг мөрдөж ажиллах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгө дутуу илэрхийлсэн	1	38,171.3			1	38,171.3	1	38,171.3				
Өр төлбөр дутуу илэрхийлсэн	1	132,876.9	1	132,876.9			1	132,876.9				
Дүн	2	171,048.2	1	132,876.9	1	38,171.3	2	171,048.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг мөрдөөгүй	1	10,300.0					1	10,300.0				
Дүн	1	10,300.0					1	10,300.0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ТӨХК	1	1			1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Анхан шатны хяналт хийсэн:
Аудитын менежер

Хоёр дах шатны хяналт хийсэн:
Дарга, тэргүүлэх аудитор

Т.Намжил огноо:

М.Бат-Амгалан огноо:

М.Батсуурь огноо:

